

*Б.Даваасүрэн - ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 8032 дугаар дамжааны суралцагч,
цагдаагийн хтиууч*

*Ю.Бадамханд - ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Цагдаагийн удирд.чага, стратегийн профессорын
багийн дэд профессор, доктор (Ph.D)
цагдаагит хурандаа*

ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хураангуй: Онцгой нөхцөл байдлын тухай ойчголт, онцгой нөхцөл байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрхэн удирдан зохион байгуулах талаар тодорхойлохыг зоричоо.

Түлхүүр үгс. Онцгой нөхцөл байдал, нийтийн хэв журам. олон нийтийн аюулгүй байдал.

Оршил: Цаг агаарын эрс тэс өөрчлөлт, байгаль орчны тэнцвэрт байдлын алдагдлын улмаас байгалийн гамшиг, аюулт нөцгой үзэгдлийн давтамж сүүлийн жилүүдэд байнга нэмэгдэж түүний улмаас учирч буй хор хохирол, аюул занал, хөнөөлийн цар хурээ, хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа нь ард, иргэдийн хэвийн амьдрах нөхцөлд нөлөөлөөд зогсохгүй улмаар улс, нийгмийг ч бүхэлд нь хамарсан аюул, хор уршгийг бий болгож онцгой нөхцөл байдал, гамшиг, ослын хэмжээнд хүрэх явдал гарсаар байна.

Дээрх онцгой нөхцөл байдлын үед цагдаагийн байгууллага нь гүйцэтгэх үйл ажиллагаа, чиг үүргийн хувьд оролцож бусад хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах, зарим тохиолдолд удирдан зохион байгуулах, үүссэн нөхцөл байдлыг түргэн шуурхай хэвийн нөхцөл байдалд оруулах олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай болдог.

Нэр томъёо:

- Аюул
- Онцгой нөхцөл байдал (гамшиг, аюулт үзэгдэл, осол зэрэг)
- Нийтийн хэв журмыг зөрчих, олон нийтийн аюулгүй байдлыг алдагдуулах
- Таслан зогсоох
- Нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлын үүргээ биелүүлж буй цагдаагийн алба хаагчийг эсэргүүцэх
- Өөрийн хүч, арга хэрэгсэл
- Нөхцөл байдал

- Нөхцөл байдал хүндэрсэн үеийн хамгаалалт
- Хамгаалалтын төрөл, хэлбэр, зохион байгуулалт
- Хамгаалалтын төлөвлөгөө, зураглал

Онцгой нөхцөл байдал гэж - Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол. гал гүймэр. хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үе.¹

Аюулын төрөл:

- о Бодит аюул
- о Болзошгүй аюул

Ангилал:

1. Байгалийн гаралтай аюул

- Цаг зуурын гэнэтийн - байгаль цаг уурын нөлөөгөөр төр, нийгэм, бие хүний ашиг сонирхолд учирч болох аюул.
- Экологийн - хүрээлэн буй орчинтойгоо зүй бус харьцсаны улмаас байгалийн янз бүрийн юмс үзэгдлийн нөлөөгөөр төр, нийгэм, бие хүний ашиг сонирхолд учирч болох аюул.

/Үер, хуй салхи, газар хөдлөлт, зуд, ган, бусад аюулт үзэгдэл/

2. Хүмүүний гаралтай аюул

- улс төр
- эдийн засаг
- цэрэг
- соёл иргэншил
- шинжлэх ухаан, техник
- мэдээллийн аюул

/довтолгоон, доромжлол, хулгай, халдлага, тэсэрч дэлбэрэх бодис дэлбэрэх, химийн хорт, аюулт бодис алдагдах, тархах, үйлдвэрлэлийн горим журам алдагдах/

Түүнчлэн аюулыг: хэлбэрээр нь шууд ба шууд бус, хугацаагаар нь гэнэтийн, хэсэг хугацааны, хэсэгчилсэн, сэм; хор уршгаар нь эргэж нөхөгдөхгүй, эргэж нөхөгдөх, давуу байдалтай; чиглэлээр нь гадаад, дотоод; ач холбогдлоор нь зөвшөөрөгдөх, үл зөвшөөрөгдөх; бүрэлдэхүүнээр нь нэг удаагийн, хосолсон, халдан шингэх; гарал үүслээр нь нийгэм, техник, байгалийн; болох эсэхээр нь магадлалтай, бүрэн боломжтой, бодит, биелэгдэхүйц; учир шалтгаанаар нь зүй тогтлын, санамсаргүй; шатлалаар нь

¹ Б.Баянмөнх, "Онцгой нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа", УБ, 2013 он.

гараг хоорондын. (дэлхийн). бүс нутаг, улс хоорондын, орон нутгийн, хувь хүний г.м. ангилсан байдаг.

“Олон нийтийн аюулгүй байдал” - байгалийн гамшиг, гэнэтийн осол болон байгууллага, хүмүүсээс хүрээлэн байгаа орчин, эд зүйл, механизмтай зүй бус харьцсанаас хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөд учирч болох хор хөнөөлийг арилгах, таслан зогсоох. түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрх зүй, зохион байгуулалт, техникийн хэм хэмжээг ойлгоно.^{1,2}

“Нийтийн хэв журмыг зөрчих, олон нийтийн аюулгүй байдлыг алдагдуулах” - хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмын хэм хэмжээг үл ойшоосон, зөрчсөн үйлдэл хийх, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, нийтийг хамарсан арга хэмжээг тасалдуулах, бие махбодийн хүчирхийлэл хийхэд чиглэсэн идэвхитэй үйлдэл хийх, айлган сүрдүүлэх зорилгоор үгээр болон биет байдлаар хийсэн сэтгэл санааны хүчирхийлэл үзүүлэхийг;

“Таслан зогсоох” - гэмт үйлдлийг хориглон зогсооход чиглэсэн идэвхитэй ажиллагааг. Харин гэмт этгээдийг гуйх, ятгах, ухуулах болон сургамжлах зэргийг нийтийн хэв журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоосон гэж үзэхгүй;

“Нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг үүргээ биелүүлж буй цагдаагийн алба хаагчийг эсэргүүцэх” - нийтийн хэв журам зөрчих, олон нийтийн аюулгүй байдлыг алдагдуулах үйлдлийг албан үүргийн хувьд хориглон зогсоох талаар идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа цагдаагийн алба хаагч /төрийн төлөөлөгч/-ийн шаардлагыг үл ойшоох, биелүүлэхгүй байх, түүний эсрэг бие махбодийн, эсхүл сэтгэл санааны аливаа хүчирхийлэл үйлдэхийг. Эсэргүүцэх нь хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх хэлбэрийн алинаар нь ч илэрхийлэгдэх бөгөөд энэ үед эсэргүүцлийн ямар ч үйлдэл хийгдсэн байж болно;

“Нөхцөл байдал” - үйл явдлын явц, өрнөл, өөрчлөлтийг;

“Өөрийн хүч, арга хэрэгсэл” гэж гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй бүтэц, орон тоо, ашиглагдаж байгаа зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын машин, бусад техник хэрэгслийг;

Онцгой нөхцөл байдал нь нийтийн аюулгүй байдалд хамаарна.

Гамшгийн үед цагдаагийн байгууллагаас хийж гүйцэтгэх ажиллагааг журамласан байна:

¹ Н.Баяраа, П.Дамдин, “Монгол оронд тохиолддог аюулт үзэгдэл, гамшиг, сургамж”, УБ.. 2006 он.

² “Тамшгаас хамгаалах тухай хууль”, 34 дүгээр зүйл, УБ., 2017 он.

а/ Үйл ажиллагааны онцлогт зохицуулан гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, алба мэргэжлийн анги, байгууллага, ажилтныг гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх чадвартай болгох, бэлэн байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах (Гамшгаас хамгаалах тухай хууль. 34 дүгээр зүйл);¹

б/ Иргэдийн эрүүл мэнд, амь нас, иргэд, аж ахуйн нэгж. байгууллагын эд хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах;

в/ Үер, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин үүссэн үед хорио. цээрийн дэглэм тогтоож, онцгой байдлын байгууллагатай хамтран ажиллах;

г/ Техникийн холбогдолтой осол, гэмтлийн үед холбогдох хууль, тогтоомж. улсын онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөө боловсруулан ажиллах;

д/ Химийн хорт бодис алдагдсан үед тухайн газар орчинд ажиллах төлөвлөгөө. зураглалыг боловсруулан хорио, цээрийн дэглэм тогтоож, төрөл мэргэжлийн албадтай хамтран ажиллах;

е/ Гамшгийн тухай мэдээг холбогдох дээд шатны байгууллагад шуурхай хүргэх.

Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох ажиллагаанд цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад **Дотоодын цэргийн командлагчийн шийдвэрээр Дотоодын цэргийг** татан оролцуулж болно.*²

Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн. малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэмийг сахиулах талаар дадлага, сургуулилтын зардал, алба хаагчдын гамшгийн үед ажиллах хамгаалах тусгай хэрэгсэл, хувцас хэрэгслэл, томиолтын зардал, бусад шаардлагатай (ариутгаж цэвэрлэх, засварлах) хөрөнгийг жил бүрийн төсөвт суулгах

Хамгаалалтын төрөл:

а/олон нийтийн арга хэмжээ (нийгэм, улс төр /жагсаал, цуглаан, ажил хаялт, суулт, эдийн засаг, улс төрийн шинжтэй уулзалт, зөвлөгөөн, чуулган/; спортын уралдаан, тэмцээн, марафон гүйлт, бусад арга хэмжээ; соёл, урлаг /баяр, ёслолын арга хэмжээ, бүх нийтийн зугаалга, шашны зан үйл/; Улсын баяр болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулагдаж байгаа бүсийн даншиг наадам, хурдан морины уралдааны үеийн; сонгуулийн)

¹"Цагдаагийн албаны тухай хууль", 2017 он.

²"Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам", 2018 он.

б/төрийн тусгай хамгаалалтын болон гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үеийн;
в/нөхцөл байдал хүндэрсэн үе /жагсаал, цуглаан, нийтийн эмх замбараагүй байдлын үе, гамшиг. онц байдал тогтоосон үе/-ийн.

Мөн:

ердийн (бие бүрэлдэхүүний 40 хүртэл хувь)

- хүчлэн хамгаалалт (бие бүрэлдэхүүний 60 хүртэл хувь) гэж ангилна.
(20-оос доошгүй хувийг нөөцөд байлгана)

Хамгаалалтын хэлбэр:

а/хөдөлгөөнт /тодорхой нутаг дэвсгэр. объектын хооронд тээврийн хэрэгсэл, морь, явганаар хөдөлгөөнтэйгөөр хийх/;

б/объектын хамгаалалт /тодорхой объект, цэг, нутаг дэвсгэрт тогтоосон хугацаанд хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах/

Хамгаалалтын зохион байгуулалт:

1. Тухайн зохион байгуулагдаж байгаа газар оронд нэвтрэх хүмүүсийн хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор тодорхой бүс, газар орчныг хааж, арга хэмжээ хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэх **Бүслэн хаах** /арга хэмжээ ажиллагааг зохион байгуулна.

- Дан ба давхар бүсийн;

Гинжин ба шугаман хамгаалалт

Бүслэн хаах газар, орныг хэсгүүдэд хуваах ба түүнийг гинжин хамгаалалтад авна.

Гинжин хамгаалалт тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан нягт буюу хагас метрт нэг алба хаагч, ердийн буюу нэг метрт нэг алба хаагч, сийрэг буюу 2 болон түүнээс дээш метрт 1 алба хаагч оногдохоор нэг буюу 2, 3, 4 эгнээтэй байж болно;

Бүслэн хаахад барилга байгууламжийн хийц, хашаа, тээврийн хэрэгсэл ашиглаж болно.

Шугаман хамгаалалт нь хүмүүсийн урсгал хөдөлгөөнийг зохицуулж, чиглүүлэх зорилгоор цагдаагийн алба хаагчдыг нэг эгнээнд зэрэгцүүлэн байрлуулна.

2. **Хамгаалалтын бүс болон түүний гадна талд:**

нийтийн хэв журам сахиулах зорилгоор Эргүүлийг;

бүслэн хаасан хэсэгт иргэдийг зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх, гаргах зорилгоор Шалган нэвтрүүлэх цэгийг тус тус ажиллуулна.

3. **Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах** ажиллагаанд хамгаалалтын байрлалыг /ЦБҮАЖ№500.566/-д заасан аргачлалын дагуу зохион байгуулна.

4. Удирдлага, хяналт

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь хариуцсан нутаг дэвсгэртээ зохион байгуулж байгаа арга хэмжээний хамгаалалтыг удирдаж, шийдвэрийнхээ биелэлт, үр дүнг хариуцна.

Нийслэлд нөхцөл байдал хүндэрч хоёроос дээш дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан, эсхүл өөрийн байгууллагын хүч, хэрэгсэл хүрэлцэхгүй болох зэрэг тухайн дүүргийн цагдаагийн хэлтсийн хүрээнээс гарсан нөхцөлд Нийслэлийн цагдаагийн газрын Штаб удирдаж, хяналт тавина.

Нөхцөл байдал хүндэрсэн эсхүл ЦБ-ын дарга шаардлагатай гэж үзсэн бол (тухайн нөхцөл байдал Нийслэлийн цагдаагийн газар, тухайн орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн хүрээнээс гарсан тохиолдолд) бүх төрлийн хамгаалалтын үед Удирдлагын болон шуурхай штаб ажиллана.

Цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар томилогдсон Шуурхай удирдлагын штаб нь Жагсаал, цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдал, гамшиг, онцгой байдал тогтоосон үеийн хамгаалалтыг удирдаж, хяналт тавина.

Орон нутагт цагдаагийн 2 ба түүнээс дээш байгууллага хамтран оролцож үүрэг гүйцэтгэх нөхцөлд цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар "Цагдаагийн түр хүрээ" байгуулан ажиллуулах ба уг тушаалаар томилогдсон албан тушаалтан удирдаж, хяналт тавьж ажиллана.

5. Бусад ажиллагаа

•S Хамгаалалтын төлөвлөгөө, зураглал

Тусгай бүлгүүд (тандан судлах, баримтжуулах бүлэг зэрэг), Тусгай ажиллагаа хариуцсан нэгж

J Бусад алба (Эрүү, Мөрдөн байцаах алба, Төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан нэгж, /цагдаагийн албан тушаалын цол бүхий алба хаагч). бусад байгууллагыг хамгаалалтад татан оролцуулах

У Хамгаалалтыг баримтжуулах (бичлэг хийх, алба хаагчдыг сургалтад хамруулах)

Хамгаалалтын төлөвлөгөө:

Цагдаагийн байгууллага нь гамшгийн нөхцөл байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөө, зураглалтай байх ба тэдгээр нь байгууллагын нууцад хамаарна. Уг төлөвлөгөө, зураглалд үүсч болзошгүй нөхцөл байдалд ажиллах арга. ажиллагааны хэд хэдэн хувилбарыг багтаасан байна.

НХЖХ, ОНАБХ албанаас хагас жил тутамд тодотгол хийх. дадлага сургуулийг зохион байгуулна.

Төлөвлөгөө, зураглалыг Нийтийн хэв журам хамгаалах. олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга хянана.

а/онц байдал зарласан үед ажиллах;

б/гамшгаас хамгаалах төлөвлөгөө /гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх. ажилтан, алба хаагчдыг гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх дадлага чадвартай болгох, бэлэн байдлыг хангуулах/;

в/нөхцөл байдал хүндэрсэн. нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед дэг журам сахиулах. хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах;

г/болзошгүй нөхцөл байдлын үеийн загвар төлөвлөгөө, зураглал /онц чухал объектын. олон улсын чанартай тэмцээн. уралдаан, урлаг, уран сайхны шоу тоглолтын үед зэргээр нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчих гэх мэт/;

д/улсын баяр наадам. олон улс болон улс, бүсийн чанартай нийтийн арга хэмжээний хамгаалалтын үеийн;

е/нэгдүгээр зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтын үеийн;

ж/орон нутагт нөхцөл байдал хүндэрсэн үед бусад цагдаагийн байгууллагуудтай хамтран ажиллах.

Онцгой нөхцөл байлын үед ажиллах хамгаалалтын төлөвлөгөөг цагдаагийн төв байгууллагын дарга батална (нийслэл хотод 24 цагийн, орон нутагт 48 цагийн өмнө батлуулсан байна). Хамгаалалтын төлөвлөгөөнд:

о хамгаалалт зохиогдох хугацаа, газар, объект

о хамгаалалтад оролцох хүч хэрэгслийн тоо

о холбооны хэрэгслийн тор, сүлжээ, дуудлага

о хамгаалалт удирдах ажлын хэсэг

о хамгаалалтад ажиллах байгууллагуудын үндсэн болон нөөц хүчний байршилт

о техник хэрэгсэл, алба хаагчдын үүрэг гүйцэтгэх цэгийг тодорхой заана.

Онцгой нөхцөл байдлын үед хамгаалалтад ажиллах цагдаагийн байгууллагын даргын үүрэг:

а/галт зэвсэг, тусгай хэрэгсэлд үзлэг хийж, тавьж олгоход бэлтгэх;

б/холбооны хэрэгслийг ажилд бэлтгэх, заасан торонд шилжүүлэх;

в/тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, шатах тослох материалаар хангах, бие бүрэлдэхүүнийг тээвэрлэхэд бэлтгэх;

г/хамгаалалт зохион байгуулах газар, объектод үзлэг хийж, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх, арилгах;

д/хамгаалалтад ажиллах алба хаагчдыг томилох;

е/ажиллах бүрэлдэхүүний хувцаслалтад үзлэг хийж, жигдрэлтийг хангах;

ж/гүйцэтгэх үүргийн онцлогт тохирсон сургалт, дадлага явуулах;

з/томилгоот бүрэлдэхүүнийг гүйцэтгэх үүрэгтэй нь холбогдуулан үүрэгжүүлэх; и/тогтоосон цаг, хариуцсан хэсэгт хүч, хэрэгслийг байрлуулах; к/хамгаалалтыг биечлэн удирдан зохион байгуулах, өгөгдсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх, хяналт тавих.¹

Дүгнэлт

Онцгой нөхцөл байдал үүссэн болон онц байдал зарласан үед цагдаагийн байгууллагаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны явцад урьдчилан таамаглагдаагүй үйл явдал үүссэн тохиолдолд гүйцэтгэх чиг үүрэг, бусад байгууллагатай хамтарч ажиллах талаар төлөвлөгөө, зураглал, эрх зүйн орчин бүрэлдэн бий болсоноор цагдаагийн албанд ашиглах техник, тусгай хэрэгслийн нөхөн хангалт сайжирч алба хаагчид үүрэг гүйцэтгэх нөхцөл бололцоо дээшилсэн гэж дүгнэж байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

1. Онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөөний дагуу зэвсэгт хүчний Жанжин штаб, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар. Онцгой байдлын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газруудтай хамтарсан нэгдсэн дадлага, сургалтыг бодит нөхцөл байдал үүсгэн зохион байгуулах.
2. Гадаадын бусад улс оронд онцгой нөхцөл байдал бодитоор үүссэн тухайн орчинд хууль тогтоомжид заасны дагуу хөндлөнгийн ажиглагчаар алба хаагч томилон туршлага судлуулах.

¹ Б.Сүхбат."Цагдаагийн шуурхай удирдлагын штабын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт".магистрын ажил. 2013 он.34 дэх тал